

Qualcomm програм хангамж, аппликэйшний талаар дэлгэрэнгүй мэдээлэл

Qualcomm компанийн салбарууд нь таны гар утас, таблетны ажиллагааг сайжруулах, батерейн цэнэгээ нөөцлөх, төхөөрөмжийн аюулгүй байдал зэргийг сайжруулах төрөл бүрийн програм хангамж, аппликэйшн, үйлчилгээг зохион бүтээн танд санал болгож байдаг. Эдгээр програм хангамжийн аппликэйшнүүдэд дараах зүйлс багтдаг:

Qualcomm Location

Qualcomm Location (Өмнө нь “IZat” гэж нэрлэгддэг байсан) нь АНУ дахь Qualcomm technologies Inc., Европын эдийн засгийн нутагт орших QT Technologies Ireland Limited, БНСУ-д орших Qualcomm CDMA Technologies (Korea) ҮН компаниудын санал болгож буй шинэ технологи юм. Qualcomm Location-ын тусламжтайгаар таны гар утас байршлыг илүү үнэн зөв, хурдан шуурхай тогтоох боломжтой болох бөгөөд таны гар утас GPS-ийн хүчтэй сигналыг хүлээн авах шаардлагагүйгээр энэ бүгдийг гүйцэтгэх боломжтой болдог.

Qualcomm Location програм нь таныг байршлын өгөгдлийг авахад шаардлагатай сүлжээ, аппликэйшнүүдийг ашиглаж байхад төхөөрөмжийн батерейгаа хэмнэх боломжийг олгодгоороо онцлог юм. Та байршил асаах аппликэйшнүүдийг ашиглаж байгаа бол таны төхөөрөмж өөрийн байршлаа эдгээр аппликэйшний компаниудад илгээж байдаг. Тухайн аппликэйшний зохион бүтээгчдэд хүрч байгаа таны байршлын мэдээлэл нь хэрэглэгчийн гэрээ, хувь хүний нууцын журмуудаар зохицуулагдаж байдаг. Бид та бүхнийг тухайн аппликэйшн зохион бүтээгчдийн эдгээр журмуудтай танилцаж үзэхийг зөвлөж байна.

Qualcomm Location нь тодорхой хугацааны интервалаар таны төхөөрөмжид ойролцоох сүлжээний цамхаг, антенн болон WiFi сүлжээний цэгүүдийн байршлын талаарх өгөгдлийг татаж авч байдаг. Энэхүү өгөгдөл нь гироскоп, акселерометр зэрэг таны гар утсан дээрх мэдрэгчүүдээс ирсэн өгөгдөлтэй нэгдэн таны төхөөрөмжийг байршил тогтоох, батерейн цэнэгийг хэмнэхэд тусалдаг.

Qualcomm Location нь тодорхой хугацааны интервалаар бидэнд таны өвөрмөц мэдээлэл болох програм хангамжийн ID болон төхөөрөмжийн байршил (уртраг, өргөрөг, өндрийн цэгүүдийг тодорхой бус мэдээллийн хамтаар) болон ойролцоох сүлжээний антенн болон WiFi hotspot, сүлжээний хүч болон цаг хугацаа (хамтад нь “Байршлын өгөгдөл”) зэргийн мэдээллийг дамжуулж байдаг. Ямар ч интернэт харилцаа холбоонд байдгийн адилаар бид мөн таны төхөөрөмжийн ашиглаж байгаа IP хаягийг хүлээн авах болно. Бид байршлын өгөгдөл, програм хангамжийн ID, IP хаяг болон бусад өгөгдлийг системийнхээ ажиллагааг хамгаалах, үнэлэх, сайжруулах зорилгоор цуглуулдаг.

Qualcomm Location нь цуглуулсан өгөгдөл мэдээллээ хамгаалахад маш олон төрлийн зохих ёсны хамгаалалтын арга хэмжээнүүдийг ашигладаг. Түүнчлэн, бид таны програм хангамжийн ID, IP хаяг болон байршлын өгөгдлийг байнгын байдлаар хадгалдаггүй бөгөөд Qualcomm Location-ын хэрэглэгчдийг нэг бүрчлэн таньж тодорхойлох үйлдлийг хийдэггүй

болно. Системийн ажиллагааг нэмэгдүүлэн сайжруулахын тулд таны байршлын мэдээллээр дамжуулан авсан програм хангамжийн ID болон IP хаяг нь анх хүлээн авснаас 30 хоногийн дараа бүрэн хэмжээгээр устаж байдаг. Бид хэрэглэгчдийн IP хаяг болон програм хангамжийн ID-ийг авсан мэдээллээс хассаны дараа байршлын өгөгдлүүдийг хуримтлуулан сүлжээний антенн болон WiFi цэгүүдийн байршилтай холбоотой нэргүй өгөгдлийг санг бүрдүүлдэг.

Хэрэв та БНСУ-д байгаа бол энэ улсад үзүүлж буй Qualcomm Location үйлчилгээ нь байршлын мэдээллийг хамгаалах хуулийг мөрдөж байдаг бөгөөд та энэхүү хууль тогтоомжийн дагуу холбогдох эрхүүдийг эдлэх эрхтэй байдаг. БНСУ дахь манай үйлчилгээний талаар тодруулах болон мэдэгдэх зүйлс байгаа бол бидэнтэй дараах хаягаар холбогдоно уу:

Qualcomm CDMA Technologies (Korea) YH
Attention Legal Department
4th, 15th, 16th & 17th Fl.
119, Nonhyeon-dong, Gangnam-gu
Seoul, 135-820
Republic of Korea
Холбогдох утасны дугаар: 82-2-3404-1114

Qualcomm Technology Reporting (QTR) – Оношилгооны тоон өгөгдлүүд

QTR нь АНУ дахь Qualcomm Technologies, Inc. болон Европын эдийн засгийн нутагт байрлах QT Technologies Ireland Limited компаниудаас санал болгож буй технологи юм. QTR нь дараах хувийн мэдээллийг цуглуулж болно: (i) Суулгасан аппликэйшний нэрүүд болон/эсвэл төхөөрөмж дээр ажиллаж байгаа аппликэйшн, (ii) Тохиргооны мэдээлэл (Үйлдвэрлэгч, модель, үйлдлийн систем, хувилбар, микропрограм болон хувилбарууд, утасгүй сүлжээ хүлээн авагч, гар утасны улсын код, сүлжээний код, чипний сериал дугаар (энэ нь таныг таниулахгүй)), (iii) Төхөөрөмжийн үзүүлэлт, аюулгүй байдлын статистик (CPU, GPU болон модемын ажиллагаа) болон (iv) мэдрэгчийн өгөгдөл- энэ нь таныг таниулж илэрхийлэхгүй боловч хөдөлгөөн, зүг чиг болон утасны орчны мэдээллийг дамжуулдаг. Өгөгдлийг нууцлал бүхий WiFi-аар ачаалах бөгөөд бага хэмжээтэй бол таны утасны дата сүлжээгээр ачаалдаг.

Бид QTR-ийн цуглуулсан өгөгдлийг энэхүү журамд дурдсан зорилгоор ашигладаг бөгөөд эдгээр өгөгдөл мэдээлэл нь дараагийн үеийн гар утасны технологийг хөгжүүлэхэд бидэнд тус болж байдгаас гадна батерейн цэнэгийн хэмнэн, аюулгүй байдлын арга хэмжээг хөгжүүлэн, бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулахад ашиглагддаг. Бид мөн энэ өгөгдөл мэдээллийг утасгүй сүлжээний операторууд болон төхөөрөмж үйлдвэрлэгчдэд өгч утасгүй төхөөрөмжүүд, сүлжээ болон аюулгүй байдлаа сайжруулахад нь тусалдаг.

QTR нь Андройд үйлдлийн системийн тохиргоо (Settings menu) цэсэнд “Qualcomm Technologies Reporting” нэртэйгээр хэрэглэгчээс өгөгдөл цуглуулалтыг цуцлах боломжтой байдлаар суусан байдаг. Та өгөгдөл цуглуулалтыг цуцалснаар таны гар утасны үйл ажиллагаанд ямар нэгэн сөргөөр нөлөөлөх зүйл байхгүй болно.

Анхаарах хэдэн зүйлс: Интернет холболтын адилаар бид таны төхөөрөмжийн ашигласан IP хаягийн өгөгдлийг хүлээн авах бөгөөд хүлээн авмагц энэ мэдээллийг нэн даруй устгадаг. Хэрэв QTR нь бидэнд энэхүү журамд тусгагдаагүй хувь хүний нууцтай холбоотой байж болзошгүй аливаа өгөгдлийг илгээсэн бол бид мөн л хүлээн авмагц энэ мэдээллийг устгадаг. QTR-ийн зарим хувилбарууд нь тухайн төхөөрөмжийн IMEI буюу олон улсын хөдөлгөөнт төхөөрөмжийн өгөгдлийг цуглуулах чадамжтай байдаг ч энэхүү чадамжийг нь бид одоогоор ашиглаагүй байгаа юм. Хэрэв ирээдүйд бид IMEI өгөгдлийг цуглуулах болбол шаардлагатай тохиолдолд ил тодорхой зорилготойгоор салбарын холбогдох хууль тогтоомж, хувийн нууцын хуулийн дагуу хийгдэх болно. Түүнчлэн QTR-ийн зарим хувилбарууд нь мөн танд бидэнд байршлын мэдээллээ илгээх тохиргоо бүхий боломжит сонголттой байдаг. Та хэрэв бидний үйл ажиллагааг дэмжин энэхүү тохиргоогоор байршлын мэдээллээ бидэнд илгээхэд, жишээлбэл, бид утасгүй сүлжээний хүчин чадал сул газруудыг тодорхойлох боломжтой болж байдаг юм.

Snapdragon Smart Protect

Qualcomm® Snapdragon™ Smart Protect нь Европын эдийн засгийн нутагт байрлах QT Technologies Ireland Limited болон АНУ-д байрлах Qualcomm Technologies, Inc. компаниудаас андройд үйлдлийн системтэй төхөөрөмжүүдэд зориулсан аюулгүй байдал хангах ухаалаг програм хангамж юм. Smart Protect буюу ухаалаг хамгаалалт нь таны төхөөрөмждөө суулгасан аппликэйшнүүдийн шинж байдлыг хянахын зэрэгцээ төхөөрөмжид суусан байж болзошгүй бусад төрлийн хорон шинж чанартай програмууд, сурталчилгаа болон мэдээлэл цуглуулагч тагнуулын програм хангамжуудын шинж байдлыг автоматаар суралцан, илрүүлж байдаг. Smart Protect нь тухайн төхөөрөмж дээр давхар суулгасан хэрэглэгчийн гуравдагч талын аюулгүй байдлыг хангах зориулалттай аппликэйшнүүдийн ч энэхүү шинж чанарыг давхар хянан мэдээлж байдаг байна.

Smart Protect програм хангамжийг сайжруулах болон энэхүү журамд бидний зүгээс заасан бусад зорилгоор Smart Protect програм нь бидэнд таны төхөөрөмжид илэрсэн хорон шинж чанартай програмууд болон тэдгээрийн илэрсэн аппликэйшний нэр, тухайн сэрэмжлүүлгийг үүсгэсэн үйлдэл, төхөөрөмжийн ерөнхий мэдээлэл болох үйлдвэрлэгчийн нэр, модель, үйлдлийн системийн хувилбар, төхөөрөмжийн хэлний тохиргоо, сүлжээ хүлээн авагч болон улсын код гэх мэт төхөөрөмжийн тохиргооны ерөнхий мэдээллүүдийг илгээж байдаг.

Vellamo

Vellamo нь Qualcomm Innovation Center, Inc-ээс Андройд үйлдлийн системтэй төхөөрөмжүүдэд зориулан хөгжүүлсэн харьцуулалт хийх зориулалттай програм хангамж

юм. Vellamo нь төхөөрөмжид суусны дараа төхөөрөмжийн системийн ажиллагааг шинжлэн, мэдээлж байдаг. Та энэ програм хангамжийн түслэмжтайгаар өөрийн төхөөрөмжийг бидний өмнө нь туршаад байгаа төхөөрөмжүүдтэй харьцуулалт хийх боломжтой байдаг. Харин энэ үед таны төхөөрөмж бидэнд харьцуулалтын дүн болон системийн мэдээллийг дамжуулдаг. Энэхүү системийн мэдээлэлд төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн нэр, модель, хувилбар зэрэг мэдээллээс гадна таны төхөөрөмжийн процессор, санах ой, мэдрэгчүүд гэх мэт техник хангамжийн мэдээлэл байхаас гадна үйлдлийн системийн төрөл, хувилбар, дэлгэцийн мэдээлэл, интернэт протоколын хаяг, хайлтын програм хангамжийн компани, таны төхөөрөмжийн дата сүлжээгээр холбогдож байгаа сүлжээний оператор зэргийн талаарх мэдээлэл илгээгдэж байдаг. Эдгээр мэдээлэл нь журамд заасан зорилгын хүрээнд хэрэглэгдэхээс гадна интернэтээс үүрэн төхөөрөмжийн ажиллагааны талаарх бодит тоон шинжилгээг нэгтгэж, таны хүссэн харьцуулалтыг хийж гүйцэтгэх бидний үйлчилгээнд ашиглагдаж байдаг.

XTRA- Predicted GNSS Satellite Orbit Data буюу ОУ-ын сансрын станцын навигацгийн системийн мэдээлэл.

XTRA нь АНУ дахь Qualcomm Technologies, Inc болон Европын эдийн засгийн нутагт орших QT Technologies Ireland Limited компаниудын үүрэн төхөөрөмжийн ажиллагааг сайжруулахад зориулан гаргасан технологи юм. XTRA нь Qualcomm компаниас GNSS- ийн хиймэл дагуулын тойрог замын мэдээллийг агуулсан дата файлыг татаж авч байдаг. XTRA дата файлыг ашигласнаар таны төхөөрөмжийн байршил тодорхойлох хугацаа багасаж, үүний дүнд байршлын аппликэйшнүүдэд зарцуулах таны цаг хугацаа болон төхөөрөмжийн батерейн цэнэг хэмнэгдэж байдаг. XTRA програм хангамжийн сүүлд гарсан шинэ хувилбарууд бидэнд таны төхөөрөмжийн талаар багахан хэмжээний мэдээллийг илгээж байдаг. Бид энэхүү илгээгдсэн мэдээллийг программ хангамжийн засвар үйлчилгээ, чанар, аюулгүй байдал болон системийн бүрэн бүтэн байдлыг хангахад энэхүү журамд заасан хүрээнд ашигладаг. XTRA програм хангамж нь дараах өгөгдлийн төрлийг бидэнд илгээдэг: санамсаргүй байдлаар үүсгэгдсэн төхөөрөмжийн өвөрмөц ID, чипний нэр, сериал дугаар, XTRA програм хангамжийн хувилбар, гар утасны операторын улсын код, сүлжээний код (уг мэдээллээр дамжуулан төхөөрөмжийн байгаа улс орон, утасгүй сүлжээний операторыг мэдэж болно.), үйлдлийн системийн төрөл, хувилбар, төхөөрөмжийн үйлдвэрлэгч, модель, процессор, модемыг хамгийн сүүлд бүүтлэсэн хугацаа болон төхөөрөмжид суусан манай програм хангамжуудын жагсаалт зэрэг мэдээлэл байдаг.